

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт

ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН /МАЯГТ 1/

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.

Тайлагнах хугацаа	2025 оны 1-р сарын 01 - 2025 оны 12-р сарын 31
Үнэт цаас гаргагчийн нэр, улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, үнэт цаасны код, утасны дугаар	СҮҮ ХК, УБГД: 000219594 ҮЦК: 135-СҮҮ Утас: 7707-2222
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын хөрөнгийн бирж
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Сүүний тээврийн үйлчилгээ Үхрийн сүүний фермерийн аж ахуй Хүнсний ногоо тариалах Малын тэжээлийн ургамал тариалах Сүү сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Эрнст Энд Янг Монголия Аудит ХХК
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	344,000,000 ширхэг
Жилийн үйл ажиллагааны тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Ерөнхий нягтлан бодогч Д.Дэлгэрэхжаргал

1	Тайлант жилийн санхүүгийн тайлан /хураангуй тайлангийн үзүүлэлтийг бөглөж, санхүүгийн тайланг хавсаргана/	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Тайланг хавсаргав.
	Орлогын тайлан	Тайланг хавсаргав.
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	Тайланг хавсаргав.
	Мөнгөн гүйлгээний тайлан	Тайланг хавсаргав.
1.1	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	
	Жилийн санхүүгийн тайлангийн дүгнэлт эерэг дүгнэлт гарсан. Аудитлагдсан тайлангийн дүгнэлтийг хавсаргав.	
1.2	Аудитын тодорхойлох захидал/тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/	
	Жилийн санхүүгийн тайлангийн дүгнэлт эерэг дүгнэлт гарсан. Аудитлагдсан тайлангийн дүгнэлтийг хавсаргав.	

2	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл	
2.1	Үйл ажиллагааны үрдүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Нийт ашгийн хувь: 29.67% Цэвэр ашгийн хувь: 5.73% Нийт хөрөнгийн өгөөж (ROA): 6.5% Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE): 18.5%
2.2	Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт	Эргэлтийн харьцаа: 1.1 Түргэн хөрвөх чадварын харьцаа: 1.8
2.3	Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл	Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн шинэчлэлт, сайжруулалтанд томоохон хөрөнгө оруулалтууд хийгдсээр байна. Үүнтэй холбоотой бүтээгдэхүүний чанар нэмэгдэх, чанартай шинэ бүтээгдэхүүнүүдийг зах зээл дээр гаргаж хэрэглэгчдэд хүргэснээр үйл ажиллагааны цар хүрээ өсч байна.

2.4	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	Санхүүгийн байдлын тайлангаас гадуур бүртгэгдсэн ажил гүйлгээ байхгүй, НБББодлого нь компанийн НББББичгийн дагуу бүртгэсэн.
2.5	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл;	Тайлант хугацаанд зээлийн бүх эргэн төлөлтүүд хугацаандаа хийгдсэн.

3	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/	
	1. "Сүү" ХК-ийн 2025 оны 02 сарын 26-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн №05 тогтоолын дагуу худалдах худалдан авах гэрээ, гүрээсийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, барьцааны гэрээ, зээлийн гэрээ, эд хөрөнгө хөлслөх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ, тээвэрлэлтийн гэрээнийг 2025 оны 02 дугаар сарын 02-ны өдрөөс 2026 оны 02 сарын 26-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаанд холбогдох дүрэм, журам, хөдөлмөрийн гэрээний хүрээнд "Макс Импекс" ХХК-тай 3,000,000,000 ₮ хүртэлх үнийн дүн бүхий сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх, гэрээ байгуулахыг зөвшөөрсөн. 2. "Сүү" ХК-ийн 2025 оны 05 сарын 12-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн №13 тогтоолын дагуу худалдах худалдан авах гэрээ, гүрээсийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, барьцааны гэрээ, зээлийн гэрээ, эд хөрөнгө хөлслөх гэрээ, тээвэрлэлтийн гэрээнийг 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрөөс 2026 оны 02 сарын 26-ны өдөр хүртэл 7 сарын хугацаанд "Мөнх ногоон тал" ХХК-тай 1,000,000,000 ₮ хүртэлх үнийн дүн бүхий сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх, гэрээ байгуулахыг зөвшөөрсөн.	

4	Цалин урамшууллын мэдээлэл	Компанийн цалингийн сүлжээний дагуу олгодог
---	----------------------------	---

5	Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл	Төлөөлөн удирдах зөвлөлтэй бөгөөд 12 гишүүнтэй, цалин урамшуулал, нэр дэвшүүлэх, аудитын, Эрсдэлийн удирдлага, комплайнсын гэх 4 хороотой.
---	--	--

6	Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл	Байхгүй
---	--------------------------------	---------

7	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/	ЖАМЪЯН: хувьцааны тоо 133103000 ГАНБААТАР: хувьцааны тоо 113730000 УЯНГАЛАНХУА: хувьцааны тоо 72240000 14012 хувьцаа эзэмшигчтэй.
---	---	--

8	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл	Байхгүй
---	--	---------

9	Ногдол ашгийн мэдээлэл	2025 оны эхний хагас жилийн байдлаар нэгж хувьцаанд 6 төгрөг, нийт 2.1 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон тарааж, 2025 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 5.09 төгрөг ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн.
---	------------------------	---

10	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл	Нийгмийн хариуцлагын хүрээнд хийсэн ажлаас товч дурдвал: ГССҮТөвтэй хамтран ажиллах санамж бичиг, "Яс булчингийн эрүүл мэнд-2025" ОУ-ын эрдэм шинжилгээний хурал, 600 гаруй хүүхэд хамарсан "Өсвөрийн шатарчдын тэмцээн", Азийн Үндэсний поммын аварга шалгаруулах волейболын тэмцээний ерөнхий нвээн тэтгэгч, СОС хүүхдийн асрамжийн газар, Кристина нобелийн сан, Өнөр бүл хүүхдийн сувилал гэх мэт олон байгууллагуудад дэмжлэг үзүүлэн, олон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн ажилласан.
----	--	--

Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Б.Гангүлгэ

Албан тушаал: "СҮУ" ХК-ийн Гүйцэтгэх захирал

Гарын үсэг:

(Тамга/тэмдэг)



Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:

Овог, нэр: Д.Дэлгэрэхжаргал

Албан тушаал: Ерөнхий нягтлан бодогч

Гарын үсэг:



МОНГОЛ улсын
УУГАН
ҮЙЛДВЭР

2025

Үйл ажиллагааны тайлан



КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

КОМПАНИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын сүү, сүүн бүтээгдэхүүний салбарын анхдагч "Сүү" ХК нь 1958 оноос хойш нийт хүн амыг чанартай, аюулгүй хүнсээр хангах эрхэм зорилгоо түүштай хэрэгжүүлж ирсэн түүхтэй. Бид олон жилийн үлэмжлэл, арвин туршлагаа орчин үеийн инновацтай хослуулан, үндэсний брэнд бүтээгдэхүүнээ үе үеийн хэрэглэгчдэд тасралтгүй хүргэсээр байна.

Өдгөө манай компани 750 орчим ажилтантайгаар, хоногт 200 тонн сүү боловсруулах хүчин чадал бүхий орчин үеийн үйлдвэрт 24 цагийн түрш үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж, 70 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг 7,000 гаруй борлуулалтын цэгээр дамжуулан түгээж байна.

Компанийн салшгүй хэсэг бол түүхий эд нийлүүлэгчид юм. Бид түүхий эдийн тогтвортой байдлыг хангах, хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг дэмжих зорилгоор малчид, фермерүүдийг нэгтгэсэн сүү бэлтгэлийн хоршооны тогтолцоог өргөжүүлэн хөгжүүлж байгаа бөгөөд өнөөдрийн байдлаар 34 хоршоо тогтвортой ажиллаж, бүс нутгийн эдийн засагт бодитой хувь нэмэр оруулж буй. Тухайлбал, Улаанбаатар хотыг төв болгон 350 км радиуст орших Төв, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Хэнтий, Булган зэрэг зургаан аймгийн 2,500 гаруй сүү бэлтгэн нийлүүлэгчидтэй хамтран ажиллаж, жилийн дөрвөн улирал тасралтгүй түүхий эд татан авах нэгдсэн логистикийн системийг бүрдүүлээд байна.

"Сүү" ХК нь хүнсний аюулгүй байдал, чанар, инновац болон тогтвортой хөгжлийг эрхэмлэн, Монголын сүүний салбарын шинэ үеийг манлайлж, хэрэглэгчдэдээ эрүүл, баталгаатай бүтээгдэхүүн хүргэхийн төлөө түүштай зорин ажиллаж байна.





АЛСЫН ХАРАА

Монгол сүүгээр
дэлхийг ундаална



ЭРХЭМ ЗОРИЛГО

Уламжлан ирсэн сүүн соёлыг
орчин үеийн хэрэгцээнд
нийцүүлэн түгээнэ



ҮНЭТ ЗҮЙЛС

67 жилийн ТҮРШЛАГА, ЭРҮҮЛ хүн,
АЮУЛГҮЙ ажиллагаа, ИТГЭЛ
даасан ЧАНАР, ЧАДВАРЛАГ хамт
олон

УРИА ҮГ

Сүүн соёлыг түгээнэ

ТҮҮХЭН ЗАМНАЛ

1941-1957

БЭЛТГЭЛ ҮЕ

- Сүү хүлээн авах 300 тасаг, цөцгийн тосны 2 үйлдвэр байгуулагдав.
- 1946 онд 300 тн цөцгийн тосыг экспортлов.
- Сүү ХК-ийн үндэс суурь тавигдав.

1986-2006

ЗАХ ЗЭЭЛИЙН ШИЛЖИЛТ, ШИНЭЧЛЭЛ

- 1991 онд хувьчлалаар төрийн өмч давамгайлсан хувьцаат компани болов.
- Үйлдвэрлэлийн хэмжээ 34 дахин буурсан хүнд үеийг түүлав.
- 2006 онд бүрэн хувьчлагдаж, шинэчлэл, хөрөнгө оруулалтын үе эхлэв.
- Орчин үеийн пюрпак савлагааны шугам нэвтрүүлэв.

1958-1985

БАЙГУУЛАГДСАН ҮЕ

- 1958 онд хоногт 30 тн боловсруулах үйлдвэр ашиглалтад оров.
- 1985 онд барилга, тонох төхөөрөмжийн шинэчлэл хийж, одоогийн СХД-т үйл ажиллагаагаа эхлүүлэв.
- Гурвалжин сүү, шилтэй тараг, аарц, аарүүл, зайрмаг зэрэг үндэсний бүтээгдэхүүнийг гаргав.

2023-2025

ШИНЭ ҮЕ – СҮҮ 2.0

- 44 тэрбум ₮ хөрөнгө оруулалт.
- Үйлдвэрлэлийн хүчин чадал 2 дахин өсөв.
- СҮҮ 2.0 төсөл эхэлж, экспортын суурь тавигдав.
- “Монгол сүүгээр дэлхийг ундаалах” шинэ шат эхлэв.

2007-2023



СТАНДАРТ, ЧАНАР

- ISO 9001, OHSAS 18001, ISO 45001 HACCP тогтолцоо бүрэн нэвтрүүлэв.
- Чанар, аюулгүй байдлын олон улсын баталгааг хэрэгжүүлэв.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧ

Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид

39%	Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч
33%	Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч
21%	Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч
5.20%	МУ-ын иргэд
1.70%	Гадаадын иргэн, хуулийн этгээд
0.1%	МУ-ын хуулийн этгээд



ҮНЭ БА АШГИЙН ХАРЬЦАА

Нийт гаргасан хувьцаа:

344,000,000


Тикер	MSE:SUU
Бирж	МХБ
Ангилал	I, TOP20 индекс
Зах зээлийн үнэ	213,706,138,701.17₮
Нээлтийн ханш	441₮
Хаалтын ханш	622.81₮
52 долоо хоногийн мэдээлэл	441.5 - 700.1₮

НЭГЖ
ХУВЬЦААНЫ
ҮНЭ

622.81₮

 **41.23%**
ӨСӨЛТ

КОМПАНИЙН БҮТЭЦ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА

"Сүү" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хувьд 8 ердийн гишүүн, 4 хараат бус гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.



Д.ГАНБААТАР
ТҮЗ-ийн дарга



Д.ЦЭРЭНЖИГМЭД
ТҮЗ-ийн гишүүн



Д.ЖАМБЯН
ТҮЗ-ийн гишүүн



Д.УЯНГАЛЯНХҮА
ТҮЗ-ийн гишүүн



Б.ТҮВШИНТӨГС
ТҮЗ-ийн гишүүн



Д.ТУНГАЛАГ
ТҮЗ-ийн гишүүн



С.СУХБОЛД
ТҮЗ-ийн гишүүн



Б.ГАНТУЛГА
ТҮЗ-ийн гишүүн



Б.БАТЗОРИГ
ТҮЗ-ийн хараат
бус гишүүн



Г.БАЯР
ТҮЗ-ийн хараат
бус гишүүн



Н.ЦЭРЭНДОРЖ
ТҮЗ-ийн хараат
бус гишүүн



Д.ДАВААНЯМ
ТҮЗ-ийн хараат
бус гишүүн

УДИРДЛАГЫН ТАНИЛЦУУЛГА



Б.Гантулга
Гүйцэтгэх захирал



Д.Бямбажав
Үйлдвэртэй хариуцсан
дэд захирал



Д.Баасаногт
Үйлдвэртэй хариуцсан
дэд захирал



Г. Пэлжидмаа
Маркетинг, борлуулалт
хариуцсан дэд захирал



Б.Алтанхишиг
Эрдэнэт салбар үйлдвэр
хариуцсан дэд захирал



Б.Ганзориг
Агро бизнес хариуцсан дэд
захирал



Б.Амарбаясгалан
Сүү худалдан авалтын
албаны дарга



С.Кристина
Худалдан авалт, Холбооны
албаны дарга



Б.Ариунболд
Захираа, Хуулийн албаны
дарга



Л.Байгальмаа
Хүний нөөцийн албаны
дарга



Ц.Батгэрэл
Чанар, Лабораторийн
албаны дарга



С.Оюунбилэг
Технологийн албаны
дарга



Ц.Баасандорж
Тээвэр, Полицийн
албаны дарга



Ш.Хаш-Эрдэнэ
Маркетингийн
албаны дарга



П.Эрдэнэбаатар
Улаанбаатар хот
хариуцсан борлуулалтын
албаны дарга



С.Отгонбаатар
Төхөөрхний албаны
дарга



М.Батцэцэг
Дотоод аудитын албаны
дарга

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, хамтрагч түншүүд ээ,

2025 он бол "Сүү" ХК-ийн хувьд тогтвортой өсөн дэвших бодлогыг баримталж, бодит үр дүнд хүрсэн стратегийн томоохон шилжилтийн жил байлаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн зүгээс бид компанийн үрт хугацааны үнэ цэнийг нэмэгдүүлэх, зах зээл дэх байр суурийг бэхжүүлэх, санхүүгийн сахилга бат болон хариуцлагатай удирдлагын зарчмыг түүштай хэрэгжүүлэхэд анхаарч ажиллалаа.

Тайлант хугацаанд бүтээмжийг дээдэлж, хэрэглэгчийг идэвхжүүлэх, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн гаргах багагүй ажлын үр дүнд борлуулалтын нийт орлого 221.4 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 29 тэрбум төгрөгөөр өссөн нь компанийн түүхэн амжилт билээ.

Үүгээр зогсохгүй сүүн гэр бүлийн өөр нэгэн амжилт бол сүү татан авалтын хэмжээ. Тэртээ 1988 онд Монгол Улсын сүү татан авалтын хэмжээ 28 сая литрт хүрч байсан нь тухайн үеийн хамгийн өндөр үзүүлэлт хэмээн тэмдэглэгддэг. Харин 2025 онд "Сүү" ХК дангаараа 31.2 сая литр сүү татан авснаар энэ амжилтыг давж, салбарын шинэ дээд хэмжээг тогтоосныг цохон тэмдэглэхэд таатай байна.

Энэхүү түүхий эдийн бааз өргөжүүлэх, малчид фермерүүдтэй хамтран ажиллах бодлого ирэх жилүүдэд ч тогтвортой үргэлжилнэ. Энэ хэрээр бид үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлэх шаардлагатай тулаад буй. Иймээс тайлант онд эхлүүлсэн үйлдвэрлэлийн хүчин чадлыг тэлэх "Сүү 2.0" төсөл нь компанийн дараагийн 10 жилийн өсөлтийн суурийг бататгаж, хоногт боловсруулах сүүний хэмжээ 400 тонн болон нэмэгдэж байна. Шинэ технологи, дэвшилтэт тоног төхөөрөмж, олон улсын стандартын шаардлагад нийцсэн үйлдвэрлэлийн орчин бүрдүүлж буй энэхүү хөрөнгө оруулалт нь дотоодын зах зээлд төдийгүй бүс нутгийн хэмжээнд өрсөлдөх боломжийг нэмэгдүүлнэ гэдэгт итгэл дүүрэн байна.

Мөн "Сүү" ХК нь Монголын нээлттэй хувьцаат компаниудын дунд манлайллаа дахин бататгаж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс" -ийн хэрэгжилтийг өмнөх оноос давуулан биелүүлж, 100 хувьтай байгаа нь манай компанийн нээлттэй, ил тод, тэнцвэртэй засаглалын тогтолцоог бий болгож ажиллагдийг илэрхийлэх хамгийн том илрэл юм.

Бидний тухайд компанийн үнэ цэнийг зөвхөн санхүүгийн үзүүлэлтээр хязгаарлахгүйгээр түүхий эдийн тогтвортой байдал, малчид фермерүүдтэй хамтран хөгжих бодлого, хүний нөөцийн чадаах болон нийгмийн хариуцлагыг чухалчилж байгаа бөгөөд ил тод засаглал, тогтвортой хөгжлийн зорилтууд болон хариуцлагатай бизнесийн зарчмууд нь Төлөөлөн удирдах зөвлөлийн бодлогын цөмд хэвээр байх болно. Түүнчлэн, "Сүү" ХК нь үйлдвэрлэлийн шинэ шатанд гарч, зах зээлээ тэлэн, ашигт ажиллагаагаа нэмэгдүүлж, хувьцаа эзэмшигчдэд үрт хугацааны бодит өгөөж бий болгох стратегия түүштай хэрэгжүүлэх болно хэмээн Төлөөлөн удирдах зөвлөлийн нэрийн өмнөөс илэрхийлье.



Сүү ХК-ийн
Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

Д.Ганбаатар

Хүндэтгэсэн,
"Сүү" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга
Д.Ганбаатар

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч түншүүд, үнэнч хэрэглэгчид ээ,

Та бүхэнд энэ өдрийн амар амгаланг айлтган, "Сүү" ХК-ийн 2025 оны санхүү, үйл ажиллагааны ололт амжилтыг тайлагнан мэндчилж байна.

Өнгөрсөгч он бол манай компанийн хувьд санхүүгийн сахилга батыг чанд баримталж, дэд бүтэц болон үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлсэн онцгой жил байлаа. Юуны өмнө, олон улсын санхүүгийн зах зээлд нэр хүндтэй ЕСБХБ-аас (EBRD) авсан зээлийг бүрэн төлж дуусгаснаар бид санхүүгийн бие даасан байдлаа бататгаж, мөн 6 жилийн дараа 5 тэрбум төгрөгийн өрийн хэрэгсэл "Сүү 2.0" бондыг зах зээлд цаг хүрэхгүй хугацаанд амжилттай арилжавллаа. Бондын нийт захиалга богино хугацаанд дүүрэхээс гадна, товлосон 5 тэрбум төгрөгийг давж 7 тэрбум төгрөгийн захиалах хүсэлт ирсэн нь санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлээд зогсохгүй иргэд, аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө оруулалтын оролцоог сайжруулах чухал боломжийг бүрдүүлсэн билээ.

Мөн аливаа байгууллагын бизнесийн үйл ажиллагаа бараа бүтээгдэхүүн, хэрэглэгч дээр тогтдог учиртай. Иймээс бид хэрэглэгчийн хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагад үндэслэн шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэн, зарим нэр төрлийн бүтээгдэхүүний хөгжүүлэлтийг сайжруулан ажиллалаа. Дурдвал, бид термоформ савлагааны шинэ шугамыг ашиглалтад оруулснаар PROVITA йогурт, шинэ савлагаатай "Сайхан сүү", БНСУ-ын алдарт Lavelee брэндийн зайрмагийг албан ёсны эрхтэйгээр хэрэглэгчдэдээ хүргээд буй.

Монгол хүн бүрийн өдөр тутмын хэрэглээ болсон сүү сүүн бүтээгдэхүүн бүрийн ард үнэнчээр хөдөлмөрлөж буй "Сүүн гэр бүл" байдаг билээ. Иймд манай компани шинэ ажлын байр нэмэгдүүлж, ажилтнуудынхаа үр чадварыг дээшлүүлэх системтэй сургалтуудыг зохион байгуулснаас гадна ажилтнуудаа дэмжих орон сууцны болон хүримтлалын хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүллээ. Энэ нь тогтвортой хөгжлийн бодлогын нэг хэсэг бөгөөд бид бусад үйл ажиллагаандаа ч тогтвортой хөгжлийн зорилтууд ногоон, хариуцлагатай бизнесийг зарчмыг баримтлан ажиллаж байна. Жишээлбэл, нийгмийн хариуцлагын хүрээнд боловсрол, эрүүл мэнд, спортын чиглэлээр "Milk Festival-2025", "СҮҮ 365" шатрын тэмцээн, "Яс булчингийн эрүүл мэнд олон улсын эрдэм шинжилгээний хурал" зэрэг нийгэмд үнэ цэн бүтээсэн олон төсөл, арга хэмжээг санаачлан хэрэгжүүлсэн юм.

Ийнхүү бид 2025 оныг санхүүгийн хувьд тогтвортой, үйлдвэрлэлийн хувьд тэлсэн, нийгмийн хувьд хариуцлагатайгаар өнгөрөөгөөд байна. Энэхүү хамтын зүтгэлийн үр дүнд "Сүү" ХК нь 2025 оны "ШИЛДЭГ АЖ АХУЙ НЭГЖ" -ээр шалгарч, ТӨП-100 ААН-ийн 56-р байрт эрэмбэлэгдлээ.

Бид 2026 оноос Монголын сүүний салбарыг шинэ түвшинд гаргах их замналдаа түүштэйгаар урагшлах болно.

Та бүхэнд чин сэтгэлийн талархал илэрхийлье.



"Сүү" ХК-ийн
Гүйцэтгэх захирал

Б.Гантулга

**Үйл ажиллагааны
тайлан**

СҮҮ ТАТАН АВАЛТЫН ДЭЭД ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООЛОО

Сүүлийн жилүүдэд түүхий эдийн баазаа системтэйгээр өргөтгөж, үндэсний хэмжээнд тогтвортой, хариуцлагатай нийлүүлэлтийн сүлжээг бүрдүүлэхэд анхааран ажиллаж ирлээ. 2025 онд "Сүү" ХК 31.2 сая литр сүү татан авч, түрүү оны амжилтаа ахиулан компанийн 67 жилийн түүхэн дэх татан авалтын хэмжээг шинэчлэн тогтоосон нь энэхүү бодлогын бодит үр дүн юм. Энэ нь эрэлт нийлүүлэлтийн өсөлттэй уялдуулан малчид, фермерүүдтэй урт хугацааны, харилцан ашигтай хамтын ажиллагааг бэхжүүлэх ажлын нэг бөгөөд хоршоодын тоо нэмэгдсэнээр сүү бэлтгэлийн үр ашигтай систем бүрэлдэж, орон нутгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэх бодит нөхцөл бүрдэж байна.

СҮҮ ХУДАЛДАН АВАЛТЫН НИЙТ ХЭМЖЭЭ



ҮХРИЙН ҮРЖЛИЙГ САЙЖРУУЛАХ ХАМТАРСАН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

"Үхрийн зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх сургалт"-ын хүрээнд "Сүү" ХК-ийн гишүүн хоршоодыг хамруулан Нутаг академи, Малын үдмйн сангийн үндэсний төв, GLOBAL CIVIC SHARING-тай хамтран долоо хоногийн вакумжуулсан сургалтыг хоёр дахь жилдээ амжилттай зохион байгууллаа.



Global
Civic Sharing
НЭГДЭЛЭН



НУТАГ
АКАДЕМИ



НЭГДЭЛЭН
ЦӨВ



МАЛЧИД, ФЕРМЕРҮҮДЭД 447 ТН ЭРДЭНЭШИШИЙН ДАРШ ОЛГОЛОО

"Сүү" ХК 2024-2025 оны өвлийн улиралд сүү бэлтгэн нийлүүлдэг **2,500** гаруй малчин, фермерүүдийг дэмжих зорилгоор нийт **447** тонн эрдэнэшишийн дарш тараан олголоо. Энэхүү дэмжлэг нь өвлийн улиралд малын тэжээллэг чанарыг хадгалах, ашиг шимийг тогтвортой байлгах, сүүний гарцыг бүүрүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж буйгаараа онцлог юм.

Тэжээлийн дэмжлэг нь зөвхөн малчдын өвөлжилтөд туслахаас гадна хэрэглэгчдийг шинэ, чанартай сүүгээр тасралтгүй хангаж буй хэлбэр билээ.



СҮҮ 2.0 ТӨСӨЛ

2025 онд "Сүү" ХК үйлдвэрлэл, технологийн шинэчлэл, инновац, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн чиглэлд стратегийн томоохон хөрөнгө оруулалтыг үе шаттай хэрэгжүүлсэн бөгөөд үүний томоохон илэрхийлэл нь "Сүү 2.0" төсөл юм. Энэхүү төсөл нь компанийг үйл ажиллагааг нэг алхмаар урагшлуулж, олон улсын стандартад нийцсэн үйлдвэрлэлийн цогц орчныг бүрдүүлэх зорилготой үрт хугацааны стратегийн хөрөнгө оруулалт юм.

Шинэ үйлдвэр ашиглалтад орсноор үйлдвэрлэлийн хүчин чадал 2-3 дахин нэмэгдэж, хоногт **400 гаруй** тонн сүү, сүүн бүтээгдэхүүн боловсруулах боломж бүрдэнэ. Ингэснээр дотоодын өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангахын зэрэгцээ бүтээгдэхүүний нэр төрөл, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг өргөжүүлэх бодит боломж нээгдэж байна. Төслийн онцлох давуу тал нь эрчим хүч, дулаан, цахилгааны хэмнэлттэй, автоматжуулалт өндөртэй дэвшилтэт технологийг нэвтрүүлж буйд оршино. Ингэснээр үйлдвэрлэлийн үр ашиг дээшилж, нөөцийн зарцуулалт буурч, тогтвортой, байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэлийн шинэ загвар бүрэлдэж байна.




ДЭВШИЛТЭТ ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ШИНЭЧЛЭЛ

"Сүү" ХК нь 2025 онд үйлдвэрлэлийн үр ашиг, хүчинчадлыг нэмэгдүүлэх зорилгоор техник, технологийн иж бүрэн шинэчлэлийг шат дараатай хэрэгжүүллээ. Энэхүү ажлын хүрээнд термоформ савлагааны шугамыг нэвтрүүлснээр савлах үйл явцыг бүрэн автоматжуулав.

Мөн үйлдвэрлэлийн бүтээмжийг өсгөж, өртөг хэмнэх чиглэлд Итали улсын "IMAR" брэндийн гурилан аяга хэвлэх, жигнэх машиныг ашиглалтад оруулсан нь эрчим хүчний хэрэглээг үлэмж бууруулж, эдийн засгийн хэмнэлт бий болгосон бөгөөд үйлдвэрлэлийн явцад гарч буй дайвар бүтээгдэхүүнийг вакум өтгөрүүлэгч төхөөрөмжөөр дахин боловсруулж, нэмүү өртөг шингэсэн түүхий эд болгон ашиглаж эхэлсэн нь нөөцийг бүрэн дүүрэн, үр ашигтай зарцуулах чухал шийдэл болоод байна.

Эдгээр технологийн шинэчлэлүүд нь компанийн үйл ажиллагааг улам боловсронгуй болгож, зах зээлд өрсөлдөх чадварыг бататгахад жинтэй хувь нэмэр орууллаа.



БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН

"Сүү" ХК нь өглөө бүр малчид, фермерүүдээс татан авсан сүүгээр хэрэглэгч, олон нийтэд эрүүл, чанар стандартын шаардлага хангасан 70 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн шинэхнээр нь хүргэн ажиллаж байна.



ЗАХ ЗЭЭЛД ШИНЭЭР НЭВТРҮҮЛСЭН БҮТЭЭГДЭХҮҮН

PROVITA ЙОГУРТ

Итали Улсын Sacco системийн Synbio 100 ашигтай бактеритай амьд йогурт Provita нь 2025 оны гуравдугаар сараас эхлэн Монгол Улсын зах зээлд амжилттай байршиж, өдгөө хэрэглэгчийн талархлыг хүлээгээд байна. Өдөр бүр хэрэглэгчдийн гарт шинэхнээрээ очих энэхүү йогурт нь гэдэсний бичил орчныг дэмжих, дархлаа сайжруулах, нарийн тоосонцрын харшлын шинж тэмдгийг бүүруулах, хоол боловсруулах системийг дэмжих зэрэг олон талын ач тустай бүтээгдэхүүн юм.



LAVELEE ЗАЙРМАГ

БНСУ-ын алдарт Lavelee брэндийн Eternal spring BAR, MANGO 30% BAR, Banana chocochip, Double ting зэрэг бүхэл жимс болон жимсний нухашны агууламж өндөртэй витамин, антиоксидант, эрүүл мэндийг дэмжих пробиотикоор баялаг гэдгээрээ онцлог дөрвөн төрлийн зайрмагийг "Сүү" ХК Монгол Улсад албан ёсны эрхтэйгээр, хэрэглэгчдэд хүргэж байна. Үг бүтээгдэхүүн нь хэрэглэгчдийн сэрүүцэх, эсвэл амттан идэх хүсэлд нь тусалж, эрүүл мэндэд ч анхаарах бүтээгдэхүүн юм.



АЧАА ТЭЭВРИЙН 10 АВТОМАШИНЫГ ХҮЛЭЭН АВЛАА



“Сүү” ХК нь олон улсын хүнсний тээврийн стандартад бүрэн нийцсэн, хөргүүртэй ган бүхээг бүхий 10 ширхэг ачаа тээврийн автомашиныг МСМ Группээс хүлээн авлаа. Эдгээр автомашинууд нь “Сүү” ХК-ийн сүү, сүүн бүтээгдэхүүнийг хэрэглэгч олонд чанар, стандартыг алдагдуулахгүйгээр аюулгүй, шинэхнээр нь хүргэхэд үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэл дүүрэн байна.

ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

СУРГАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО

Сургалт хөгжлийн бодлогын хүрээнд дотоод болон гадны мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх, мэргэжлийн олон талт үр чадварыг нэмэгдүүлэх зорилгоор жилийн турш хэрэгцээт сургалт хөгжлийн цогц хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Техник, технологи зэрэг нарийн мэргэжлийн ажилтнууд гадаад эксперт, зөвлөхүүдтэй хамтран ажиллаж, ажлын байран дээрээ туршлага солилцож хөгжих боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Англи хэлний үр чадварыг бүх ажилтнуудын чадавхыг сайжруулах зорилгоор мэргэжлийн сургалтын төвтэй хамтран ажиллахаар төлөвлөж байна.



ТОГТВОРТОЙ АЖИЛЛУУЛАХ БОДЛОГО

Жил бүр тогтвортой, өндөр гүйцэтгэлтэй ажилтнуудын орон байрны нөхцөлийг сайжруулах зорилгоор ажилтанд орон сууцны урьдчилгаа олгох хөтөлбөрийг тогтмол хэрэгжүүлж байна. Мөн Хуримтлалын хөтөлбөрийг 2025 оноос санаачлан хэрэгжүүлж, ажилтан үндсэн ажилтан болсон даруйдаа хуримтлал үүсгэх боломжийг бүрдүүлж, 5 жил тогтвортой ажилласнаар санхүүгийн үр ашиг хүртэх боломжийг олгож байна.



КАРЬЕР, ХӨГЖИЛ

Компанийн хэмжээнд ажилтнууд компани дотроо тогтвортой, үр чадвараа гарган ажилласан тохиолдолд мерит зарчмаар карьерын босоо болон хөндлөн карьерын өөрчлөлтийг тогтмол хэрэгжүүлж байна.



ХҮНИЙ НӨӨЦ

Сүү ХК нь тэгш хүртээмжтэй, олон талт оролцоог хангасан "Хүн төвт" бодлогын хүрээнд ажилтнуудынхаа чанартай амьдралын баталгаа болон сайн сайхан байдлыг дэмжин ажиллаж байна. Нийгэмдээ хувь нэмэр, үнэ цэн бүтээхийн тулд ажилтан бүр оролцоотой, хөгжих сэтгэлгээтэй, ёс зүйтэй байхыг эрмэлздэг.



730

НИЙТ АЖИЛТАН

ЭМЭГТЭЙ АЖИЛТАН

38.4% 6
УДИРДАХ
ТҮВШНИЙ

ЭРЭГТЭЙ АЖИЛТАН

61.6% 12
УДИРДАХ
ТҮВШНИЙ

9.39 ДУНДАЖ
АЖИЛЛАСАН
ЖИЛ

4.76 ДУНДАЖ
АЖИЛЛАСАН
ЖИЛ

25

АХУАД
АЖИЛТНЫ ТОО

21

ХӨГЖЛИЙН
БЭРХИЛЭЭЛТЭЙ
АЖИЛТНЫ ТОО

103

2025 ОНД
ШАНСОР
БИЙ БОЛСОН
АЖИЛТНЫ ТОО

24

ГЭРЭЭТ
АЖИЛТНЫ
ТОО

30

ХҮҮХД АСРАХ
ЧӨЛӨӨТЭЙ БАЙГАА
АЖИЛТНЫ ТОО

ОРОН СУУЦЖУУЛАХ ХӨТӨЛБӨР

"Сүү" ХК нь "Сүүн гэр бүл"-ийн шилдэг 4 ажилтанд сар шинийн босгон дээр орон сууцны үрьдчилгаа олгон урамшууллаа.

Компанийн тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд бид жил бүр үлэмжлал болгон шилдэг ажилтнууддаа дэмжлэг үзүүлдэг бөгөөд энэ жил нийт 180,000,000 төгрөгийн дэмжлэгийг олголоо.



"АЖИЛТАН БҮР ЭЗЭН" ХУВЬЦААЖУУЛАХ ХӨТӨЛБӨР

"Сүү" ХК-ийн хувьд ажилтан бүр ажилдаа эзний ёсоор хандаж, тэрхүү бүтээсэн үнэ цэнээ хүртдэг байх соёлыг түүштай хэрэгжүүлж байна. Энэхүү зорилтын хүрээнд компанид өөрийн мэдлэг, үр чадвар, идэвх зүтгэлээ зориулж, 5 болон түүнээс дээш жил тогтвор суурьшилтай ажилласан ажилтнууддаа компанийн хувьцааг эзэмшүүлж байна. Ингэснээр ажилтнууд компанийнхаа ирээдүйн үнэ цэн, өсөлт, хамтын амжилтынхаа үр шимийг ХАМТДАА хуваалцах боломжийг бүрдүүлж байна.

УЯН ХАТАН, ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ АЖЛЫН БАЙР



“Сүү” ХК нь ажилтан бүрдээ тэгш, хүртээмжтэй, хүний эрхийг дээдэлсэн, уян хатан ажлын орчныг бүрдүүлэхийг нэн тэргүүний зорилтоо болгон ажилладаг. Бид ажилтнуудынхаа ажил, амьдралын тэнцвэрийг дэмжиж, тэдний сайн сайхны төлөө дараах бодит ажлуудыг тогтмол хэрэгжүүлж байна.

Үүнд:

Ажлын уян хатан зохицуулалт:

Цагийн уян хатан бодлогыг нэвтрүүлснээр ажилтнууд цагаа үр дүнтэй төлөвлөх боломжийг бүрдүүлдэг.

Эрүүл мэндэд ээлтэй ажлын байр:

Жил бүр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүх ажилтнаа тогтмол хамруулж, ажлын байран дээр фитнес заалаар хичээллэх боломжоор ханган, байгууллагын ресторанд амт чанартай, шим тэжээлтэй өдрийн хоол болон фитнес цэсээр өдөр бүр үйлчилж байна.

Ажилтнуудын физиологийн болон сэтгэлзүйн эрүүл мэнд, аюулгүй байдлыг дэмжин Хүний их эмч бүтэн цагаар, сэтгэлзүйч хагас цагаар хамтран ажиллаж байна.

Тогтвортой ажлын байр

Сүү ХК-ийн ажилтнууд гэнэтийн ослын даатгалд бүрэн хамрагддаг бөгөөд мөн ажлын чиг үүргээс хамаарч 1-2 онцгой нэмэлт даатгалд ажилтнууд маань хамрагдаж, аюулгүй, эрсдэлгүй, баталгаатай ажлын байраар бүрэн хангагдаж байна.

АЯ ТУХТАЙ АЖЛЫН ОРЧИН

"Сүү" ХК нь ажилчдынхаа ая тухтай, эрүүл, бүтээмжтэй ажиллах орчин нөхцөлөөр хангах зорилгоор дараах ажлуудыг амжилттай хэрэгжүүлж байна. Үүнд:

Мөрөөдлийн цэцэрлэг

"Сүү" ХК-ийн дэргэдэх 120 хүүхдийн багтаамжтай "Мөрөөдлийн цэцэрлэг"-ийг ашиглалтад оруулж, хоёр дахь жилдээ амжилттай үйл ажиллагаа явуулж байна.



Ресторан

Манай байгууллага нь 24 цаг тасралтгүй үйл ажиллагаагаа явуулдаг билээ. Иймд гурван ээлжийн ажилчдад зориулан шим тэжээл, эрдэс баялгаар дүүрэн, эрүүл, чанартай өглөө, өдөр, оройн хоолоор үйлчлэх байгууллагын ресторан ажиллуулж байна.



SUU фитнес

Ажилчид "SUU" фитнесийн орчинд өөрийн ажлын цагийн хуваарь, ачааллаас хамааран тохиромжтой цагт мэргэжлийн багшийн удирдлаган дор хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмж ашиглан бие бялдар, эрүүл мэндээ дэмжих боломжтой билээ.





ЁС ЗҮЙН ХОРОО

Ёс зүйтэй манлайлал, бодлогыг түгээх, бизнесийн ёс зүйн зарчим, хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ёс зүйн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч шийдвэрлэх зорилгоор түс хороо үйл ажиллагаагаа явуулж байна.

ШҮГЭЛ ҮЛЭЭХ ЖУРАМ

Сүү ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн №27 дугаар тогтоолоор "Шүгэл үлээх журам"-ыг баталсан.

Энэхүү журмын хүрээнд тус компани нь хууль тогтоомж болон ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөх, байгууллагын ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор шүгэл үлээх тогтолцоог хэрэгжүүлж байна.

Журмын дагуу ажилтан болон холбогдох талууд аливаа зөрчил, эрсдэлийн талаар нууцлалтай, аюулгүй сүвгээр мэдээллэх боломжтой бөгөөд мэдээлэгчийг аливаа дарамт, ялгаварлан гадуурхалтаас бүрэн хамгаалах зарчим баримталдаг.



Вэб сайт:
<https://suu.mn/whistle-blower>

Цахим шуудан:
wb@mongolmilk.mn

КОМПАНИЙН ДОТООД ИДЭВХЖҮҮЛЭЛТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

"Сүү" ХК-ийн хувьд нэгдмэл соёл, үнэт зүйл, хамтын зорилго, баг хамт олны уур амьсгалыг тасралтгүй сайжруулах зорилгоор олон төрлийн идэвхжүүлэлтийн үйл ажиллагааг жилийн турш зохион байгуулдаг. Онцгойлон сонирхлын клубуудыг дэмжин ажилладаг.

Спортын клубуудын хувьд компанийн хэмжээнд шигшээ баг болон сонирхогчийн бүрэлдэхүүнтэй бөгөөд жил бүр компанийн хэмжээнд SUU CUP спортын олон төрөлт тэмцээнийг тогтмол зохион байгуулдаг билээ.

SUU FC - Хөл бөмбөгийн клуб

Хөл бөмбөгийн клуб анхан шатны сонирхогчоос эхлэн Спортын мастер цолтой тамирчин, удирдлагын багийн төлөөллөөс бүрдсэн гишүүнчлэлтэй бөгөөд зуны турш гадаа талбайд тогтмол хичээллэдэг. Жилдээ 1-2 удаагийн сонирхогчийн тэмцээн оролцдог.



BLUE BULL - Сарсан бөмбөгийн клуб

Сарсан бөмбөгийн эрэгтэй, эмэгтэй багийн бүрэлдэхүүн жилийн турш спорт зааланд хичээллэж, тогтмол бэлтгэлээ хангадаг. Мөн жилдээ 2-3 удаагийн сонирхогчийн тэмцээнд компанийн шигшээ багийн бүрэлдэхүүнээр амжилттай оролцдог.



SUU - Гар бөмбөгийн клуб

Тус клуб нь эрэгтэй, эмэгтэй багийн бүрэлдэхүүнтэй бөгөөд жилийн турш спорт зааланд 7 хоног бүр тогтмол хичээллэж, бэлтгэлээ хангадаг. Жилдээ 2-3 удаагийн сонирхогчийн тэмцээнд компанийн шигшээ багийг бүрдүүлэн оролцдог.





E SPORT CLUB

Тус клубын хувьд жилдээ 2 удаагийн И-спортын аварга шалгаруулах дотоодын тэмцээн зохион байгуулж, 2-3 удаагийн сонирхогчийн тэмцээнд шигшээ багийг бүрдүүлэн оролцдог.

Тоглодог төрлүүдийн хувьд PUBG mobile, CS:GO, Mobile Legends, PS5, FIFA гэх мэт.



SUU DARTS CLUB

Тус клубын гишүүдийн хувьд ажлын байран дээр, цайны цагаар тогтмол бэлтгэлээ хангаж хичээллэдэг ба жилдээ 1-2 удаагийн тэмцээнд баг бүрдүүлж оролцдог.



SUU HIKING CLUB

Тус алхалтын клубыг Уулын үндэсний холбооны 3-р зэрэгтэй ажилтан ахалдаг бөгөөд сард 1-2 удаа амралтын өдрүүдээр хол ойрын явган аяллыг зохион байгуулж, нийт ажилтнуудын хөдөлгөөний эрүүл мэндийг дэмжин ажилладаг.



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ – БОНЗ



Монгол Улсын ууган үйлдвэр "Сүү" ХК нь нийгэм, эдийн засаг болон байгаль орчинд ээлтэй бизнесийн зарчмыг баримтлан, компанийн алсын хараа, нийгмийн хариуцлагын бодлогоо тогтвортой хөгжлийн чиг баримжаатай нягт үялдуулан хэрэгжүүлж байна.

Энэхүү стратегийн хүрээнд бид эх орондоо эрүүл, аюулгүй хүнсний хэрэглээг хэвшүүлэх, тэгш хүртээмжтэй ажлын байр бий болгох замаар улс орныхоо хөгжилд бодит хувь нэмэр оруулж, байгаль орчин, нийгэм, засаглалын (БОНЗ/ESG) зарчмуудыг үйл ажиллагаандаа үе шаттайгаар нэвтрүүлсээр ирлээ.

Бидний хэрэгжүүлж буй эдгээр бодлого, санаачилгууд нь нийгэмд эерэг өөрчлөлт авчирч, салбарын тогтвортой хөгжлийг түүчээлнэ гэдэгт итгэлтэй байна.

"Сүү" ХК нь оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого:

Үг бодлогын хүрээнд бид хууль тогтоомж, ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөж, ил тод, шударга харилцааг эрхэмлэн ажиллаж байгаа бөгөөд харилцан хүндэтгэлтэй, нээлттэй хамтын ажиллагааг дэмжсэнээр итгэлцэлд суурилсан урт хугацааны түншлэлийг хөгжүүлж, нөөцийн үр ашигтай хэрэглээ болон хариуцлагатай үйлдвэрлэлийг бэхжүүлэхэд анхаарч байна.

БОНЗ-ын мэдэгдэл

"Сүү" ХК нь тогтвортой хөгжил, байгаль орчин, нийгэм засаглал /БОНЗ/-ын хүрээнд 2026 онд дараах зорилтуудыг тавьж ажиллана.

Байгаль орчны зорилт:

- 2026 онд үс цэвэрлэх байгууламж ашиглалтад оруулж саарал үсны менежментийг хэрэгжүүлнэ. Хог хаягдлын менежментийг сайжруулж 3R арга хэмжээг хэрэгжүүлнэ. Олон улсын хүлэмжийн хийг тооцох аргачлалын дагуу нэгж бүтээгдэхүүнд ногдох хүлэмжийн хийн ялгарлыг 0.0002 тонн CO₂ экв./ширхэг-т барина.
- Нарны сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангах эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлнэ.

Нийгмийн зорилт:

- Ажилчдын энгэйжментийн түвшнийг 6%-д хүргэхийг зорино. Сүү худалдан авалтын 10 хоршоо шинээр байгуулж, хөдөө орон нутагт бэлтгэн нийлүүлэгчдийн сүү хүлээн авах дэд бүтцийг хөгжүүлнэ.
- Сүүний хэрэглээг нэмэгдүүлж, хүүхэд бүрийн сүүний хэрэглээг олон улсад хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнд хүргэх зорилгоор "Сүү 365" кампанит ажлыг үргэлжлүүлж, цар хүрээг нэмэгдүүлнэ.

Засаглалын зорилт:

- 2022 оны 03 сарын 23-ны өдрийн №145 тоот Санхүүгийн зохицуулах хорооны тогтоолоор баталсан "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийг 98%-д барина.
- Компанийн комплаенсийн соёлыг төлөвшүүлж, шүгэл үлээх тогтолцоог хэрэгжүүлнэ.

Хүнсний аюулгүй байдлын зорилт:

- Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо ISO 22000:2018 стандартын нийцлийг хангаж ажиллана.



МЕНЕЖМЕНТ, БҮТЭЭГДЭХҮҮНҮҮДЭД ЭДИЙН ЗАСГИЙН НОГООН ШИЛЖИЛТИЙГ ХИЙСЭН АНХДАГЧДЫН НЭГ БОЛЛОО



Европын Холбооны СВИЧ-Эйшиа хөтөлбөрийн санхүүжилтээр хэрэгжиж буй "Эдийн засгийн ногоон шилжилт" (Switching On the Green Economy- SOGE) төсөлд "Сүү" ХК хамрагдаж, "Менежмент"-ийн болон Миний монголын сүү, Элгэн тараг, Цөцгийн тос гэсэн гурван бүтээгдэхүүн дээр "Эко тэмдэгт"-ийн гэрчилгээг гардан авснаар Монгол Улсын хүнсний салбарын БОНЗ буюу ESG-ын гэрчилгээтэй анхдагчдын нэг боллоо.

Хөтөлбөрийг Пипл Ин Нийд ОУТББ (PIN), Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо ТББ (ToC Холбоо), Хөгжлийн шийдэл ТББ болон Каритас Чех Репаблик ОУТББ (CCR) хамтран хэрэгжүүлсэн бөгөөд нийтдээ 340 гаруй төрлийн үнэлгээг хийж, шалгууруудыг хангаснаар бизнесийн үйл ажиллагааг илүү ногооруулах, тогтвортой хөгжлийн зорилтоо бататгах алхам болж буй.

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

НИЙТ ХОГ ХАЯГДЛЫН

7.2%-ийг

дахин боловсруулсан

“Сүү” ХК нь уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, байгаль орчны тогтвортой байдлыг хангах зорилгоор хог хаягдлын менежментийг системтэйгээр хэрэгжүүлж байна. Бид үйлдвэрлэлийн явцад гарсан хаягдлыг эх үүсвэр дээр нь энгийн, хүнсний болон дахин боловсруулах боломжтой гэсэн үндсэн төрлүүдэд ангилан ялгах зарчмыг баримталдаг.

Энэхүү ажлын үр дүнд 2025 онд нийт үүссэн хог хаягдлынхаа 7.2 хувийг дахин боловсруулсан нь нөөцийг үр ашигтай зарцуулах чиглэлд гарсан бодит ахиц боллоо. Цаашид бид хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах бодлогыг түүштэй баримталж, дахин боловсруулалтын түвшинг шат дараатай ахиулах замаар байгаль орчинд ээлтэй бизнесийн соёлыг төлөвшүүлэн түгээн дэлгэрүүлэхээр зорьж байна.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛД ХИЙГДСЭН АЖИЛ, ХЭМНЭЛТ, ҮР АШИГ

ХЭМНЭЛТИЙН МЭДЭЭЛЭЛ ТҮЛШНИЙ ХЭРЭГЛЭЭ

"Сүү" ХК нь түлшний хэрэглээг оновчлох, хүлэмжийн хийн ялгаралыг бууруулах зорилгын хүрээнд автомашины паркийн шинэчлэл, технологийн сайжруулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Энэхүү шинэчлэлийн хүрээнд шатахуун зарцуулалт өндөр, хуучирсан тээврийн хэрэгслүүдийг түлшний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй автомашинаар солих, ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр нийт түлшний хэрэглээ мэдэгдэхүйц буурч, улмаар хүлэмжийн хийн ялгарал багасах нөхцөл бүрдсэн.

Цаашид "Сүү" ХК нь тээврийн менежментийг ухаалаг системээр удирдах, маршрут оновчлох, шатахуун зарцуулалтыг хянах дижитал шийдлүүдийг нэвтрүүлэх замаар нүүрстөрөгчийн үл мөрийг бууруулах бодлогыг тасралтгүй хэрэгжүүлэхээр зорьж байна.

2024 он

668,420 л

2.6

ТЭРБУМҮ

2025 он

566,909 л

1.9


ТЭРБУМҮ

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСЫН ХЭРЭГЖИЛТ

"Сүү" ХК-ийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байх ба хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн Удирдах Зөвлөл байна. "Сүү" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь нийт 12 гишүүнтэй бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд компанийн үйл ажиллагааг байнга тогтмол, мэргэжлийн удирдлагаар хангаж, Компанийн тухай хууль, Төрийн болон холбогдох эрх бүхий байгууллагаас батлан гаргасан дүрэм, журам болон компанийн удирдлагын бодлого, "Компанийн засаглалын кодекс"-ийн дагуу, гүйцэтгэх захирлуудтай хамтран ажилласан.

Санхүүгийн зохицуулах хорооноос шинэлэн баталсан "Компанийн засаглалын кодекс"-ийн дагуу Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам болон бодлогын баримт бичгүүдэд нэмэлт өөрчлөлт оруулан, шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тухайлбал, "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтээ жил бүр сайжруулан, анхаарч ажиллаж байгаа бөгөөд 2025 онд 100 хувийн гүйцэтгэлтэй гарсан байна.



ХЭРЭГЛЭГЧИЙН ИДЭВХЖҮҮЛЭЛТ

"Сүү" ХК нь 2025 онд "90 САЯТАН - ТАРГИЙН БАЯР", "БАЙРТАЙ СҮҮ", "ИШТЭЙ АЗТАН" зэрэг урамшуулалт хөтөлбөрийг хэрэгжүүлж, хэрэглэгч олон нийтийг урамшуулан нийгэмд, хэрэглэгчдэд итгэл төрүүлэхүйц олон үйл ажиллагаа зохион байгууллаа.



*Иштэй
Азтан*



СҮҮ ХК БОЛОН ГССҮТ ХАМТРАН АЖИЛЛАЖ ЭХЭЛЛЭЭ



"Сүү" ХК нь "Эрүүл, чийрэг, монгол хүний төлөө" уриатайгаар хэрэгжүүлж буй SUU 365 хөтөлбөрийн хүрээнд Гэмтэл Согог Судлалын Үндэсний Төв (ГССҮТ)-тэй хамтран ажиллах санамж бичиг байгууллаа.

Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд ГССҮТ-ийн эмч, мэргэжилтнүүд ЕБС-ийн 500 гаруй сурагчид зориулан "Бодит орчинд нь танилцах" нэртэй практик сургалтыг зохион байгуулах юм. Сургалтаар хүүхдүүдийг аюул осол, гэмтлээс хэрхэн урьдчилан сэргийлэх, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлэх талаар мэдлэг, дадлага олгоно.

Энэхүү санаачилга нь Монголын хүүхдүүдийг эрүүл, чийрэг, аюулгүй өсөж торних нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээний нэг бөгөөд цаашид хамрах хүрээгээ тэлж, олон нийтэд эерэг нөлөө үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

МОНГОЛ УЛСАД АНХ УДАА “MILK FESTIVAL-2025”-ЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

“Дэлхийн сүүний өдөр” (World Milk Day)-ийг тохиолдуулан Монгол Улсад анх удаа “Milk Festival-2025”-ыг ХХААХҮЯ, НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (FAO), үндэсний томоохон үйлдвэрлэгчид болох 5 компанитай хамтран зохион байгууллаа.

Түүнчлэн, уг өдрөөр “Сүү” ХК нь хамтран ажиллагч малчид, фермерүүдийнхээ бэлэг болгон хүргүүлсэн 10,000 литр сүүг “Дэлхийн сүүний өдөр”, “Хүүхдийн баяр”-ыг тохиолдуулан “Milk Festival-2025”-д хүрэлцэн ирсэн мянга, мянган хүүхэд багачуудынхаа эрүүл мэнд, ирээдүйд зориулан амттай, мөн эрүүл бүтээгдэхүүн болгон үйлдвэрлэж бэлэглэлээ.



ЯС, БУЛЧИНГИЙН ЭРҮҮЛ МЭНД-2025 ОУ-ЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

**20 BONE
& MUSCLE
25 HEALTH**
International conference



Монгол Улсад анх удаа зохион байгуулагдсан "Яс, булчингийн эрүүл мэнд - 2025" олон улсын эрдэм шинжилгээний хурлын ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллаж, хамтран зохион байгуулан монгол хүний яс, булчингийн эрүүл мэндийг дэлхийн түвшний судалгаа, шийдэлтэй холбон олон улсын анхаарлын төвд орууллаа.



“СҮҮ” ХК 500 ГАРУЙ ХҮҮХЭД, БАГАЧУУДЫГ СҮҮН СОЁЛЫГ ТАНИУЛАХ АЯЛАЛД ХАМРУУЛЛАА

Үндэсний ууган үйлдвэр “Сүү” ХК нийгмийн хариуцлагын хүрээнд тавдугаар сарын турш ерөнхий боловсролын 10 гаруй сургуулийн 500 гаруй хүүхэд, багачуудыг “Сүү” ХК-ийн үйлдвэртэй танилцах аялалд урин оролцууллаа.

Энэхүү үйл ажиллагаа нь зөвхөн үйлдвэрийн танилцуулга төдийгүй, хүүхэд залуусыг эрүүл хүнсний хэрэглээний зөв дадалд уриалсан, нээлттэй, боловсрол олгох сайн туршлага болж чадсан гэдэгт итгэл дүүрэн байна.



НЭЭЛТТЭЙ ФЕРМ

"Сүү" ХК нь "Эрдмийн өргөө" сургууль болон "Хос бэрс агро ферм"-тэй хамтран ерөнхий боловсролын 3000 гаруй сурагчийг сүүний фермийн үйл ажиллагаатай танилцууллаа.

Сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох, хичээлийн цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэхэд өндөр үр дүнтэй туршлага болсон хэмээн найдаж байна.



СҮҮ 365 ӨСВӨРИЙН ШАТАРЧДЫН ТЭМЦЭЭН



"Сүү" ХК-ийн үлэмжлал болгон зохион байгуулдаг өсвөрийн шатарчдын тэмцээнийг "БИ ӨДӨР БҮР СҮҮ УУДАГ ОЮУНЛАГ ТАМИРЧИН" уриан дор Монгол Улсын зүүн хязгаарын Дорнод аймаг, хойд хязгаарын Хөвсгөл аймаг, өмнөд бүсийн Өмнөговь аймаг болон бусад аймаг, нийслэлээс 5-18 насны нийт 600 гаруй өсвөрийн шатарчныг хамруулсан нь онцлог байв.

Тэмцээнийг нийт 35 сая төгрөгийн шагналын сантайгаар зохион байгуулсан бөгөөд шатраар хичээллэдэг хүүхэд бүрд ижил тэгш оролцох боломжийг олгож, оюун ухаанаа хөгжүүлэн, авьяас чадвараа нээх, ирээдүйгээ итгэл төгс бүтээхэд нь бодитой хувь нэмэр орууллаа.

СПОРТЫГ ДЭМЖИГЧ

Спортыг дэмжигч "Сүү" ХК нь Вьетнам улсад зохион байгуулагдсан волейболын эмэгтэйчүүдийн Азийн цомын аварга шалгаруулах тэмцээнд Монгол Улсын шигшээ багийн ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллалаа. Тус тэмцээнд манай тамирчид амжилттай оролцсоноор дэлхийн чансаагаа 166-аас 68-р байр хүртэл огцом ахиулсан түүхэн амжилтыг үзүүллээ.





“ТОП-100 ААН”-ИЙН ЖАГСААЛТАД БАГТАЖ, 24 БАЙР УРАГШИЛЛАА

Хүнсний салбарын манлайлагч “Сүү” ХК “ТОП-100 аж ахуйн нэгж”-ийн жагсаалтад 56-р байрт эрэмбэлэгдэж, эх орныхоо эдийн засаг, эрүүл хүнсний хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буйгаа дахин батлан харууллаа.

2025 оны эхний нэгдүгээр хагаст сүүн соёлыг түгээгч “Сүү” ХК нь ТОП 100-д багтаж, 24 байр урагшилсан нь том амжилт юм. Энэхүү амжилтад “Сүү” ХК-д сүү нийлүүлдэг Улаанбаатар хотын 350км-ийн радиуст байрлах 6 аймаг, 2500 гаруй малчид, фермерүүд болон сүү сүүн бүтээгдэхүүнийг үнэтэй хувь нэмэр оруулагч 750 орчим ажилтан, алба хаагч хэрэглэгч олны амжилт юм.

МОНГОЛ УСЛЫН ШИЛДЭГ ААН-ЭЭР ДАХИН ТОДОРЧ МӨНГӨН МЕРКУРИ ЦОМЫН ЭЗЭН БОЛЛОО

Монголын бизнесийн салбарын хөгжил, үнэ цэнийг олон улсын түвшинд ойртуулж ирсэн МҮХАҮТ-ын нэр хүндтэй "ENTREPRENEUR" шагнал гардуулах ёслол 28 дахь жилдээ зохион байгуулагдаж, "Сүү" ХК 2025 оны ШИЛДЭГ АЖ АХҮЙ НЭГЖ-ээр шалгарч, Монголын бизнесийн салбарын чанар, итгэлцлийн бэлгэ тэмдэг болсон "МӨНГӨН МЕРКУРИ" цомын эзэн боллоо.



“ШИМТ СҮҮ”, “ХОРХОЙ ААРУУЛ” МОНГОЛЧУУДЫН ИТГЭЛИЙГ ДААЖ, “АРД ТҮМНИЙ ХҮНС-2026”-ААР ТОДОРЛОО

Монголын хүнсний салбарын нэр хүндтэй шалгаруулалт болох “Ард түмний хүнс-2026”-аар “Сүү” ХК-ийн хоёр бүтээгдэхүүн зэрэг тодорлоо.

Хэрэглэгчдийн санал, салбарын шинжээчдийн үнэлгээгээр “Шимт сүү”, “Миний Монголын Хорхой Ааруул” нь “Ард түмний хүнс-2026” хэмээх эрхэм өргөмжлөлийг хүртэж, хэрэглэгчдийн сонголтыг дахин нэг удаа баталгаажуулсан юм.



СХД-ИЙН ҮЙЛДВЭР, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН САЛБАРЫН ШИЛДЭГ БАЙГУУЛЛАГААР ШАЛГАРЛАА

Шинэ оны босгон дээр үндэсний үйлдвэрлэлийн салбарт тогтвортой үйл ажиллагаа явуулж, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ хариуцлагатай хэрэгжүүлэн, хүн амыг эрүүл хүнсээр хангах бодлогыг хэрэгжүүлэхэд оруулсан бодит хувь нэмрийг өндрөөр үнэлж, СХД-ийн Үйлдвэр үйлдвэрлэлийн салбарын шилдэг байгууллагаар “Сүү” ХК шалгарлаа.



ХӨРӨНГӨ ТАТАХ ШИНЭ ШАТ – “СҮҮ” ХК ХОЁР ДАХЬ БОНДОО АМЖИЛТТАЙ ГАРГАЛАА



“Сүү” ХК нь 2017 онд Монголын хөрөнгийн биржээр дамжуулан “Сүү бонд”-ыг олон нийтэд нээлттэй арилжаалж, нийт зургаан тэрбум төгрөгийн санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлж байв. Анхны бондыг найман жилийн өмнө гаргаж байсан бол Сүү 2.0 бондыг жилийн 17% хүүтэйгээр зах зээлд амжилттайгаар гарган 5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүллээ. Ингэснээр хөрөнгийн зах зээлийг дахин идэвхжүүлсэн онцлох үйл явдал боллоо.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2025 онд бүтээгдэхүүний шинэчлэл, инновацид тулгуурласан хөгжлийн бодлого бодит үр дүнд хүрч, компанийн үйлдвэрлэл болон борлуулалтын цар хүрээ мэдэгдэхүйц тэлсний үр дүнд "Сүү" ХК-ийн нийт борлуулалтын орлого 221.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 15 хувиар ахисан үзүүлэлттэй байна.



2025 оны байдлаар Сүү ХК-ийн цэвэр ашиг 13 тэрбум төгрөгт хүрлээ.


ЦЭВЭР АШИГ (Тэрбум төгрөг)




2025 оны байдлаар Сүү ХК-ийн нийт ашиг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 14% өсөж 65.7 тэрбум төгрөгт хүрлээ.

Компани 2025 онд томоохон тоног төхөөрөмжүүдийг шинэчилж, үйлдвэрлэлийн бүтээмж болон хүчин чадлыг нэмэгдүүлж өртөг зардлыг бууруулснаар нийт ашиг нэмэгдлээ.

НИЙТ АШИГ (Тэрбум төгрөг)



ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ



ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

Гэрээт ажлын баг



Гэрээт ажлын партнер

Д. Мандахбаяр



Аудитын баг:

Ахлах Менежер

Б. Хабылхайрат

Менежер

Б. Чимэдлхам

Ахлах аудитор

Н. Солонго

Туслах аудитор

туслах аудитор (5)



Чанарын хяналтын партнер

Адриан Чу



Гэрээт ажлын дэмжих баг

Партнер

Катеринэ Юуен

Ахлах Менежер

Күйний Лау



Татварын баг

Партнер

Р. Хишигнэмэх

Ахлах Менежер

Ц. Оргил

Ахлах

Б. Мөнхсаруул



Үнэлгээний баг

Партнер

Ивоннэ Дунн

Ахлах Менежер

Трэйнг Лианг

Ахлах

Шүминг Жанг



IT баг

Партнер

Тэдрэнс Лиү

Ахлах Менежер

А. Доржсүрэн

Туслах аудитор

туслах аудитор (1)



Глобал чиглүүлэлтийн баг

Партнер

Шагун Махешвари

Менежер

Шилли Жайн



2025 оны 11-р сар

2025 оны аудитын ажлын хугацаа

2026 оны 4-р сар



EY | Building a better working world

EY is building a better working world by creating new value for clients, people, society and the planet, while building trust in capital markets.

Enabled by data, AI and advanced technology, EY teams help clients shape the future with confidence and develop answers for the most pressing issues of today and tomorrow.


EY teams work across a full spectrum of services in assurance, consulting, tax, strategy and transactions. Fueled by sector insights, a globally connected, multi-disciplinary network and diverse ecosystem partners, EY teams can provide services in more than 150 countries and territories.

All in to shape the future with confidence.

EY refers to the global organization, and may refer to one or more, of the member firms of Ernst & Young Global Limited, each of which is a separate legal entity. Ernst & Young Global Limited, a UK company limited by guarantee, does not provide services to clients. Information about how EY collects and uses personal data and a description of the rights individuals have under data protection legislation are available via ey.com/privacy. EY member firms do not practice law where prohibited by local laws. For more information about our organization, please visit ey.com.

© 2026 Ernst & Young.
All Rights Reserved.

ey.com



ТӨЛӨӨЛӨН
УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН

“СҮҮ” ХК-ИЙН ТҮЗ-ИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

I. ТҮЗ-ИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

№	Үзүүлэлт	Дундаж оноо	Санал тайлбар
1	Үндсэн илт үүргийн хэрэгжилт	110	
2	ТҮЗ-ийн бүтэц, бүрэлдэхүүн	23	
3	ТҮЗ-ийн ажлын зохион байгуулалт	103	
4	ТҮЗ-ийн дарга	51	
5	ТҮЗ-ийн даргад хараах хороодын үнэлгээ	46	
6	Аудитын хороо	20	
7	Цалин урамжуулын хороо	5	
8	Нэр дэвшигчдийн хороо	25	

I. ТҮЗ-ИЙН ГҮШҮҮДИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

№	ТҮЗ-ийн гишүүний овог нэр	Дундаж оноо	Санал тайлбар
1	Д.Ганбатар	121	
2	Ц.Цэрэнсүх	121	
3	Д.Жамъян	104	
4	Б.Гантулга	125	
5	Б.Түвшинтөгс	102	
6	Д.Уянсаленкуа	114	
7	Д.Тугалаг	125	
8	С.Сүрбэлд	120	
9	Г.Баяр	112	
10	Д.Давднанм	116	
11	Б.Батзориг	117	
12	Н.Цэрэндорж	117	

I. ТҮЗ-ИЙН ГҮШҮҮДИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

№	ТҮЗ болон хороодын дагуу талууд	№	ТҮЗ болон хороодын сүл талууд	№	ТҮЗ болон хороодын үйл ажиллагаанд тулгарах буй асуудлууд	№	Цалин урамжуулын уламжлалт тус, дүн, хэмжээ
1	Хороод бүр 2 өрөөл бүс тусгайтай		ТҮЗ-ийн 4 өрөөл бүс тусгайтай				Гүйцэтгэл, хяналт, хяналтгүй
2	Тус хорооны хараахын ТҮЗ-ийн тусгайтай						Хүрнэ, зөвхөн хяналтгүй

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХҮРЛЫН 2025 ОНЫ ИРЦИЙН МЭДЭЭЛЭЛ

ОЮУНГАЛАН ТҮШААЛ	КАРЬГАЛДАХ ХОРОО	АЖЛЫН ТҮРШЛЭЛ	ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ГҮВЬ, ХЭМЖЭЭ	ИРЦ
Д.ГАНБААТАР Төлөөлөн удирдах хорооны гишүүн	НЭГДЭВЖИЛЭЛТ ХӨРӨӨ	2012 оноос 2025 он хүртэл	33.00% 100%	
Д.ЦЭРЭНСҮХ Төлөөлөн удирдах хорооны гишүүн	ЦАЛИН УРАМЖУУЛЫН ХОРОО	2012 оноос 2025 он хүртэл	50.00% 100%	
Д.ЖАМЯН Төлөөлөн удирдах хорооны гишүүн		2012 оноос 2025 он хүртэл	38.70% 100%	
Б.ГАНТУЛГА Төлөөлөн удирдах хорооны гишүүн		2014 оноос 2018 хүртэл 2025 он	50.00% 9.7%	
Б.ТҮВШИНТӨГС Төлөөлөн удирдах хорооны гишүүн		2012 оноос 2025 он хүртэл	3.660.000.00 25.8%	
Б.УЯНСАЛЕНКУА Төлөөлөн удирдах хорооны гишүүн		2012 оноос 2025 он хүртэл	22.06% 85.9%	
Д.ТУГАЛАГ Төлөөлөн удирдах хорооны гишүүн	АЖЛЫН ТҮРШЛЭЛ	2018 оноос 2025 он хүртэл	60.00 100%	
С.СҮРБЭЛД Төлөөлөн удирдах хорооны гишүүн	ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ХӨРӨӨ	2010 оноос 2025 он хүртэл	50.00% 100%	
Г.БАЯР Төлөөлөн удирдах хорооны гишүүн	ЦАЛИН УРАМЖУУЛЫН ХӨРӨӨ	2012 оноос 2025 он хүртэл	50.00% 0%	
Б.БАТЗОРИГ Төлөөлөн удирдах хорооны гишүүн	НЭГДЭВЖИЛЭЛТ ХӨРӨӨ	2025 оноос 2025 он хүртэл	50.00% 85.9%	
Д.ДАВДНАМ Төлөөлөн удирдах хорооны гишүүн	ЦАЛИН УРАМЖУУЛЫН ХӨРӨӨ	2023 оноос 2025 он хүртэл	50.00% 30.0%	
Н.ЦЭРЭНДОРЖ Төлөөлөн удирдах хорооны гишүүн	АЖЛЫН ТҮРШЛЭЛ ХӨРӨӨ	2010 оноос 2025 он хүртэл	50.00% 100%	

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх хороод



№ Овог нэр	Албан тушаал	Ажиллах албан тушаал
НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРОО		
1. Б.Бэгзориг	ТҮЗ-ийн хараат бус гишүүн	Хорооны дарга
2. Д.Ганбаатар	ТҮЗ-ийн гишүүн	Хорооны гишүүн
3. Н.Цэрэндорж	ТҮЗ-ийн хараат бус гишүүн	Хорооны гишүүн
АУДИТЫН ХОРОО		
1. Н.Цэрэндорж	ТҮЗ-ийн хараат бус гишүүн	Хорооны дарга
2. Д.Тунгалаг	ТҮЗ-ийн гишүүн	Хорооны гишүүн
3. Г.Баяр	ТҮЗ-ийн хараат бус гишүүн	Хорооны гишүүн
ЦАЛИН ҮРЭМШҮҮЛЭН ХОРОО		
1. Д.Давааням	ТҮЗ-ийн хараат бус гишүүн	Хорооны дарга
2. Д.Шэрээжитзад	ТҮЗ-ийн гишүүн	Хорооны гишүүн
3. Г.Баяр	ТҮЗ-ийн хараат бус гишүүн	Хорооны гишүүн
ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, КОМПАЙНСЫН ХОРОО		
1. Н.Цэрэндорж	ТҮЗ-ийн хараат бус гишүүн	Хорооны дарга
2. С.Сүхболд	ТҮЗ-ийн гишүүн	Хорооны гишүүн
3. Д.Давааням	ТҮЗ-ийн хараат бус гишүүн	Хорооны гишүүн

"СҮҮ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТАЙЛАН

2025 оны 12 сарын 25-н өдөр

Улаанбаатар хот

2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр хуралдсан "Сүү" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг томилж, 12 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Тайлант хугацаанд ТҮЗ нь компанийн үйл ажиллагааг тогтвортой, тасралтгүй, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллав. Мөн Компанийн тухай хууль болон холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, бусад хууль тогтоомжийг баримтлан компанийн дүрэмд зассан эрх, үүргээ хэрэгжүүлэн ажилласан болно.

Компанийн үйл ажиллагаанд дотоод хяналт, эрсдэлийн удирдлагыг сайжруулах зорилгоор дотоод аудитын бүтцийг бий болголоо. Үг хүрээнд дотоод аудитыг албан ёсоор томилж, аудитын үйл ажиллагаанд мөрдөх Аудитын дүрмийг баталлав. Ингэснээр дотоод хяналтыг бэхжүүлж, үйл ажиллагааны ил тод, үр ашгтай байдлыг хангах нөхцөл бүрдэв.

Түүнчлэн Шүгэл үлээх журмыг баталж, уг журмын хүрээнд компанид шүгэл үлээх тогтолцоог нэвтрүүллээ. Энэхүү тогтолцоо нь хууль тогтоомж болон ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөх, байгууллагын ил тод, харилцаатай байдлыг нэмэгдүүлэхэд чиглэж байна.

ТҮЗ нь компанийг зүй зохистой удирдан сайн засаглалын практикийг хэвшүүлж стратегийн удирдлагаар хангах, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавьсан.

ТҮЗ-ийн хурал Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал гишүүдийн дийлэнх олонх оролцож, тухай бүр асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд 2025 онд нийт 33 тогтоол баталсан байна. Эдгээрээс 2 тогтоол нь сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулахыг зөвшөөрсөн тухай бөгөөд холбогдох журмын дагуу олон нийтэд мэдээлсэн болно.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ НЭР ДЭВШҮҮЛЭХ ХОРООНЫ ТАЙЛАН

2025 оны 12 сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

"Сүү" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх Хороо нь Б.Батзориг, Н.Цэрэндорж, Д.Ганбаатар нарын бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд Нэр дэвшүүлэх хорооноос компанийн эрх бүхий албан тушаалтанд нэр дэвшүүлэх боломжтой этгээдийн талаар судалгаа хийж, мэдээлэл цуглуулах, үүлээлт ярилцлага хийх, нөөцийн бүртгэлд бүртгэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж ажиллалаа.

Тайлант хугацаад хорооны зүгээс дор дурдсан дүгнэлт гарган Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулсан. Үүнд:

- ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтын тухай,
- ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэх тухай,

ТУЗ-ийн гишүүд компанийн удирдлага, албан тушаалтнуудын явуулж байгаа бодлого, үйл ажиллагааны талаар санал гомдол, хүсэлт ирээгүй болно.

Түүнчлэн шинэчлэгдсэн компанийн засаглалын кодексын дагуу "Сүү" ХК-ийн Нэр дэвшүүлэх журмыг батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооноос цаашид арга хэмжээг авч хэрэгжүүлэх зөвлөж байхгүй.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ АУДИТЫН ХОРООНЫ ТАЙЛАН

2025 оны 12 сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

"Сүү" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хороо нь Н.Цэрэндорж, Д.Тунгалаг, Г.Баяр нарын бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд Аудитын Хорооноос компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон Гүйцэтгэх удирдлага нь хууль тогтоомж, компанийн дүрэм, хувь нийлүүлэгчдийн хурлаас олгогдсон эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэх, мөн компанийн санхүүгийн үйл ажиллагаанд дэд хорооны эрх үүргийн хүрээнд хөндлөнгийн аудитын байгууллагыг сонгон хяналт тавьж ажиллалаа. Тайлант хугацаанд хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-өөс өмч хөрөнгийн ашиглалт зарцуулалт, компанийн удирдлага, албан тушаалтнуудын явуулж байгаа бодлого, үйл ажиллагааны талаар санал гомдол, хүсэлт ирээгүй болно.

Нягтлан бодох бүртгэл ба тайлагнал: Компанийн санхүүгийн тайлан тэнцэл нь Монгол Улсын Сангийн Яамнаас батласан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалт", "Дансны үлгэрчилсэн заавар"-ын дагуу бэлтгэгдсэн ба Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын стандарттай нийцж байна.

Компанийн 2025 оны санхүүгийн болон удирдлагын үйл ажиллагаа нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль мөн компанийн тухай хууль болон холбогдох журам зааврын дагуу бүртгэгдээ хөтөлж санхүүгийн тайлангаа хуульд заасан хугацаанд тайлагнаж харьяа санхүүгийн болон татварын байгууллагад тушаасан байна.

Тайлант хугацаад хорооны зүгээс дор дурдсан дүгнэлт гарган Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулсан. Үүнд:

- Санхүүгийн тайлан тэнцэлд дүгнэлт гаргах тухай,
- ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны харьяа Дотоод аудитыг томилохтой холбоотой дүгнэлт гаргаж, саналт дэвшүүлэх тухай,
- Хөндлөнгийн аудит хийлгэхтэй холбоотой дүгнэлт гаргаж, санал дэвшүүлэх тухай,

Түүнчлэн шинэчлэгдсэн компанийн засаглалын кодексын дагуу хорооны үйл ажиллагааны журамд нэмэлт өөрчлөлт оруулан, батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооноос цаашид авч хэрэгжүүлэх зөвлөж байхгүй.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ЦАЛИН УРАМШУУЛЛЫН ХОРООНЫ ТАЙЛАН

2025 оны 12 сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

"Сүү" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хороо нь Д.Давааням, Г.Баяр, Д.Цэрэнжигмэд нарын бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд хорооноос компанийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх удирдлагын цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, тогтмол судалгаа хийж, бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, олгох цалин, урамшууллын дээд хязгаарыг тогтоох, тогтоосон хэмжээнд багтаан цалин, урамшуулал олгох санал боловсруулан ажиллалаа.

Тайлант хугацаанд Цалин урамшууллын хороонд санал гомдол, хүсэлт ирээгүй болно.

2025 оны 04 сарын 22-ны өдрийн "Сүү" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг томилсонтой холбоотойгоор Төлөөлөн Удирдах Зөвлөлийн цалин, урамшууллын хэмжээг тогтоосон.

ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшууллын хорооноос цаашид компанийн цалингийн систем, цалин урамшууллын бодлогыг шинэчлэхээр зорин ажиллаж байна.

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА, КОМПЛАЙНСЫН ХОРООНЫ ТАЙЛАН

2025 оны 12 сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

"Сүү" ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлага, комплаинсын хороо нь Н.Цэрэндорж, С.Сүхболд, Д.Давааням нарын бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа бөгөөд тайлант хугацаанд компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх, хянах болон комплаинсын хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд зорин ажиллаа.

Компанийн засаглалын бодлогыг дагаж мөрдүүлэх, компанид сайн засаглалын практикийг хэвшүүлэх, засаглалын кодексын хэрэгжилтийг хангах үүднээс Шүтэл үлээх журам батлахад дэмжлэг түслалцаа үзүүлэн ажиллаа.

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлага, комплаинсын хорооноос цаашид компанийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх, хянах болон комплаинсын хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэхийн төлөө холбогдох ажлыг төлөвлөн ажиллана.

КОМПАНИЙН ДОТООД АУДИТ, ТҮҮНИЙ ТОГТОЛЦОО, БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

"Сүү" ХК-ийн ТҮЗ-ийн 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн №07 тоот тогтоолын дагуу ТҮЗ-ийн дэргэдэх Дотоод аудит үйл ажиллагаа явуулж байна.

Аудитын алба нь тайлант хугацаанд гүйцэтгэх удирдлагын хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хараат бүс үнэлгээ хийж, компанийн үйл ажиллагаанд нөлөөлөх гол эрсдэлүүд болон хяналтын сайжруулах шаардлагатай чиглэлүүдийг тодорхойлж ажиллалаа.

Аудитын зөвлөмж, хэрэгжилтийн үр дүнд дотоод хяналтын найдвартай байдал сайжирч, эрсдэлийг урьдчилан илрүүлэх, удирдах чадавх бэхжин, үйл ажиллагааны ил тод байдал, хариуцлага нэмэгдэж байна. Энэ нь компанийн тогтвортой өсөлтийг дэмжих, үнэ цэнийг хамгаалах, цаашид нэмэгдүүлэхэд аудитын зүгээс оруулж буй бодит хувь нэмэр юм.

Цаашид аудитын үйл ажиллагааг стратегийн зорилттой үйлдүүлэн, эрсдэлийн удирдлага, засаглал, хяналтын тогтолцоог тасралтгүй сайжруулахад чиглүүлэн ажиллах болно.

БҮТЭЦ

Дарга

Ахлах аудитор

Аудитор



ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО

WWW.SUU.MN

ХӨРӨНГӨ
ОРУУЛАГЧДАД

БАРИМТ БИЧИГ

Компанийн тогтвортой хөгжлийн бодлого
Компанийн ногдол ашгийн бодлого
Компанийн залгамж халааны бодлого
Компанийн цалин урамшууллын бодлого
Компанийн дотоод аудитын заавар
Компанийн дотоод хяналтын заавар
Компанийн эрсдэлийн удирдлагын заавар
Компанийн комплаенсын хяналтын заавар
Хөрөнгө оруулагчтай харилцах хөтөлбөр
Компанийн эрх бүхий албан тушаалтны ёс зүйн дүрэм
Компанийн мэдээллийн ил тод байдлын тайлагналын журам
Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хураангуй
Компанийн хөрөнгө оруулалт, худалдан авалтын
ажиллах журам, сонирхлын зөрчлийн зохицуулах журам
ТҮЗ-ийн оролцооны талын бодлого
ТҮЗ-ийн нэр дэвшүүлэх журам
ТҮЗ-ийн үйл ажиллагааны журам
ТҮЗ-ийн дэргэдэх аудитын хорооны үйл ажиллагааны журам
ТҮЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журам
ТҮЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам
Аудитын дүрэм

Та энэхүү заавраар
холбогдох мэдээллийг
авах боломжтой

Гүйцэтгэх удирдлагад олгох урамшууллын гүйцэтгэлийн шалгуур

1

Компанийн
засаглалын
үнэлгээ

*(Дотоодын соёлын
судалгааны дүн)*


2

Цэвэр
ашгийн
гүйцэтгэл

3

Ажилласан
хугацаа

ТҮЗ-ийн цалин урамшууллын хэмжээ



2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ТУЗ-ИЙН ДҮГНЭЛТ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид ээ,

2025 онд "Сүү" ХК-ийн борлуулалтын орлого өмнөх оноос 29 тэрбум төгрөгөөр өсөж, 221.4 тэрбум төгрөгт хүрсэн нь манай компанийн зах зээл дэх байр суурь болон удирдлагын бодлого оновчтой байсныг баталгаажуулсан түүхэн амжилт боллоо. Тэр дундаа тэргийн борлуулалт 35 хувиар нэмэгдэж, салбартаа тэргүүлэгч болсон нь голлох нөлөө үзүүлэв. Үүний зэрэгцээ бид ЕСБХБ (EBRD)-ийн зээлийг бүрэн төлж дуусгаснаар санхүүгийн бие даасан байдлаа бэхжүүлж, өрийн дарамтыг эрс бууруулан, стратегийн хөрөнгө оруулалтуудаа бодит ажил хэрэг болгох таатай нөхцөлийг бүрдүүллээ.


Үүний үр дүнд бид үйлдвэрлэлийн хүчин чадлыг өргөжүүлэх "Сүү 2.0" төслийг урагшлуулж, 7,200 м² талбай бүхий өргөтгөлийн сүүрийг тавьснаар цаашид хоногт 400 тонн сүү боловсруулах бүрэн боломжтой болж байна. Технологийн шинэчлэлийн хүрээнд термоформ савлагааны шинэ шугамыг ашиглалтад оруулж, бүтээгдэхүүний хадгалалт, аюулгүй байдлыг сайжруулсны зэрэгцээ "PROVITA" йогурт болон шинэ савлагаатай "Сайхан сүү" зэрэг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнүүдийг зах зээлд амжилттай нэвтрүүлсэн юм.

2025 оны эхний хагас жилийн байдлаар нэгж хувьцаанд 6 төгрөг, нийт 2.1 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг болгон тарааж, 2025 оны сүүлийн хагас жилийн байдлаар нэгж хувьцаанд 5.09 төгрөг буюу нийт 1.7 тэрбум төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэн ажиллав.

Мөн санхүүжилтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх зорилгоор 5 тэрбум төгрөгийн бондыг зах зээлд арилжаалсан нь хөрөнгө оруулагчдын итгэлийг бэхжүүлсэн чухал алхам болов. Түүнчлэн, тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэгч ESG гэрчилгээг авч, "Мөнгөн Меркури" цомыг хүртэн, Монгол Улсын TOP-100 ААН-ийн 56-р байрт эрэмбэлэгдсэн нь бидний нийгэм, эдийн засагт гүйцэтгэж буй үүргийг өндрөөр үнэлсэн хэрэг байлаа.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн зүгээс 2025 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг холбогдох хууль тогтоомж, стандартын дагуу үнэн зөв тайлагнагдсан гэж дүгнэж байгаа бөгөөд бид ирэх жилүүдэд ч зах зээл дэх байр суурийг тэлж, хувьцаа эзэмшигчдийнхээ үнэ цэн, ашгийг хүртэх байдлыг нэмэгдүүлэхийн төлөө хичээнгүйлэн ажиллах болно.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын материал



НОГДОЛ АШИГ

"Сүү" ХК-ийн 2025 оны эхний хагас жилийн ногдол ашиг тараалтын тайлан болон 2025 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас ногдол ашиг тараах талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх тухай асуудал,

2025 оны эхний хагас жилийн ногдол ашиг тараалтын тайлан

"Сүү" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2025 оны 08 сарын 21-нийн өдрийн №19 тоот "Ногдол ашиг хуваарилах тухай" тогтоолоор компанийн 2025 оны эхний хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 6 төгрөг буюу нийт 2,058,792,942 төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон олгохоор шийдвэрлэсэн.

Дээрх тогтоолын дагуу 2025.12.31-ний өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тарааж дуусгав.

Нэгж хувьцаанд ногдох ашиг /₮/



2025 оны сүүлийн хагас жилд ногдол ашиг тараах тухай шийдвэр

2025 оны эхний хагас жилийн ногдол ашиг тараалтын тайлан

"Сүү" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2026 оны 02 сарын 03-ны өдрийн №03 тоот "Ногдол ашиг хуваарилах тухай" тогтоолоор компанийн 2025 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 5.09 төгрөг буюу нийт 1,746,542,679.13 төгрөгийг нийт хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг болгон олгохоор шийдвэрлэсэн.

Энэхүү шийдвэрийн дагуу 2026.04.30-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тарааж дуусгахаар шийдвэрлэсэн.

Нэгж хувьцаанд ногдох ашиг /₮/





СҮҮ ХУВЬЦААТ КОМПАНИ

МОНГОЛ СҮҮГЭЭР ДЭЛХИЙГ УНДААЛНА

Монгол улс, Улаанбаатар хот,
Сонгинохайрхан дүүрэг, Үйлдвэрчний эвлэлийн гудамж-37,
СҮҮ ХК-ийн байр